



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН
ТУШААЛ**

2012 оны 11 сарын 24 өдөр

Дугаар Б/37

Улаанбаатар хот

**“Газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ”
сэдэвт сургалтанд оролцуулах тухай**

Монгол Улсын “Төрийн албаны тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх хэсэг, “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Мэргэжилтэн Г.Цацрал, М.Отгонбаяр, Д.Санчирбаяр нарыг Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Газарзүйн хүрээлэнгийн Физик газарзүйн сектор болон Газарзүйн мэдээллийн систем, тандан судалгааны лаборатороос зохион байгуулж буй “Газарзүйн мэдээллийн системийн хэрэглээ” сургалтад 2012 оны 11 дүгээр сарын 26-наас 12 дугаар сарын 01-ний өдрүүдэд хуваарийн дагуу оролцуулсугай.

2. Дээрхи нэр бүхий мэргэжилтнүүдийн уг арга хэмжээнд оролцох сургалтын төлбөр болох 900 000 /есөн зуун мянган/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

3. Сургалтын тайлан, үр дүнг хамт олноор хэлэлцүүлж, нэр бүхий мэргэжилтнүүдийн уг сургалтын арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг ахлах мэргэжилтэн /Ц.Цолмон/-д даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН